



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2015 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/75

Улаанбаатар хот

┌ Сургалт зохион байгуулах тухай ┐


Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийг 2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.7.6, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хувь хүний хөгжлийн институт" төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан "Энгийнээр удирдахуй" сэдэвт харилцаа, хандлагын сургалтыг байгууллагын мэргэжилтнүүдэд, "Найрсаг Улаанбаатар-соёлтой такси" сэдэвт сургалтыг такси үйлчилгээ эрхлэгчдийн дунд зохион байгуулахыг Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/-д даалгасугай.

2. Сургалтын төсвүүдийг хавсралтаар баталсугай.


3. Сургалтын төсөв болох 600.000 /зургаан зуун мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2015 оны 7 сарын
27 өдрийн 17 тоот тушаалын хавсралт



ХАРИЛЦАА, ХАНДЛАГЫН СУРГАЛТЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ /төгрөгөөр/
1	"Энгийнээр удирдахуй" сургалтын төсөв	5цаг	80.000	400.000
2	"Найрсаг Улаанбаатар-соёлтой такси" сургалтын төсөв	2 цаг	100.000	200.000
	Нийт төсөв			600.000